

**"МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ" -ИЙН  
2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

№	Бодлогын зорилго, зорилт, арга хэмжээ[1]	Төсөв /сая төг/[2]		Үр дүнгийн шалгуур үзүүлэлт[3]	Суурь түвшин[4]		Зорилтот түвшин[5]		Хэрэгжилт[6]	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь[7]	Тайлбар (Хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар)[8]
		Төсөвлөсөн	Гүйцэтгэл		Он	Түвшин	Он	Түвшин			
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
<p><b>Зорилго 2.Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.</b></p> <p><b>Зорилт 2.3.Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ:</b></p>											
1	2.3.1.Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, судалгаа, нотолгоонд суурилсан, гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.	-	-	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулах	2020	Хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан.	2022	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулсан байна.	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг батлуулсан. Хуулийн төсөлд шинээр тусгах зарим асуудлын судалгааг хийсэн бөгөөд хуулийн төслийг төр, төрийн бус байгууллага, олон нийт, хуулиар эрх ашиг нь хөндөгдөх хэсгийн төлөөлөөр нийт 5 удаа хэлэлцүүлсэн. Тус яамнаас боловсруулсан Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газраас 2019 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, УИХ-ын хэлэлцэх шатанд байхад төслийг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу татан авсан. Гэр бүлийн эрх зүйн асуудал нь Монгол Улсын хууль эрх зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй иргэний эрх зүй, хувийн эрх зүйн суурь харилцааны зохицуулалтын хууль тул 2021 оноос хойш Хууль зүй, дотоод хэргийн яам голлон хариуцах болсон.	100	

2	2.3.2.хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.	22.50 0.000	22.500.00 0	Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадварыг дэмжих, урамшуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.	2020	2022	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал батлагдсан	<p>Хүүхдийн төлөө санг сэргээн байгуулах ажлын хүрээнд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулинд нэмэлт оруулах тухай болон Хүүхдийн эрхийн тухай, Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар, 04 дүгээр сарын 08-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар тус тус хэлэлцүүлэн батлуулж, Хүүхдийн төлөө санг сэргээн байгуулсан.</p> <p>Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 212.4.-т Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална гэж заасны дагуу Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ыг Засгийн газрын 2021 оны 172 дугаар тогтоолоор батлуулсан. Хүүхдийн төлөө сангаас хүүхдийн хөгжлийг дэмжсэн бүтээн байгуулалт, олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээнд амжилт гаргасан хүүхдийг шагнаж, урамшуулах, мөн олон улс, тив, дэлхийн уралдаан тэмцээнд оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Журам хэрэгжиж эхэлснээс хойших 1.7 жилийн хугацаанд автотээврийн</p>	100
---	---	----------------	----------------	---	------	------	--	--	-----

								хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлогоос 7 тэрбум төгрөг, “Хүүхдийн фонд” Төрийн Бус Байгууллагаас 2,1 тэрбум төгрөг, байгууллага, иргэдээс өгсөн хандив 15,5 сая төгрөг, нийт 9,1 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. Үүнээс: шагнал урамшуулалд 2021 онд 15 хүүхдэд 25 сая төгрөг, 2022 онд 52 хүүхдэд 113,2 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 4 хүүхдэд дэмжлэг үзүүлэхэд 23,3 сая төгрөгийг зарцуулж, хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг санхүүжилтээр дэмжих чиглэлээр зардал гараагүй байна.		
3	2.3.3. залуу гэр бүлийг дэмжсэн орчин нөхцөл сайжирна.	-	-	Нийт залуучуудын 40 хувьд гэр бүлийн зөвлөгөөг хүргэх	2020	ЗХТ-өөр үйлчлүүлсэн залуучуудын тоо 2020 онд 23 хувь	2022	ЗХТ-өөр үйлчлүүлсэн залуучуудын тоо 45 хувьд хүрсэн байна.	Залуучуудын хөгжлийн төв 21 аймаг, 9 дүүрэг, 5 сум (Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Гурвантэс, Номгон, Булган)-д ажиллаж, амьдрах ухааны сургалт, сонирхлын клуб, зөвлөлийг ажиллуулах, хууль зүйн туслалцаа, эрүүл мэндийн зөвлөгөө үйлчилгээ, тусламж, гэр бүлийн зөвлөгөө, хөдөлмөр эрхлэлтийн сургалт, зөвлөгөө, зуучлалын үйлчилгээнд жилд дунджаар нийт залуучуудын 40 хувийг хамруулдаг бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар 450 мянга гаруй залуучууд буюу нийт залуучуудын 45 хувьд хөгжлийн үйлчилгээг хүргэсэн. Мөн Ховд аймгийн Манхан сум, Баян-Өлгий	100

аймгийн Сагсай сум, Завхан аймгийн Их-Уул суманд Залуучуудын хөгжлийн төвийг шинээр байгуулаад байна. Ковид-19 цар тахлын улмаас зарим ажил, үйлчилгээ цахимжиж, залуучуудад зарим зөвлөгөө, мэдээлэл, үйлчилгээг цахимаар хүргэж байна. Тухайлбал, Цахим сэтгэл зүйн зөвлөгөө"-г 24 цагаар ажиллуулж, өсвөр үе залуучуудад сэтгэл зүйн, гэр бүлийн зөвлөгөө, мэдээлэл өгч байна. Тус үйлчилгээнд өдөрт 5-34 залуучууд жилд 600 залуучууд зөвлөгөө авч байна. Цаашид залуучуудын хөгжлийн цахим төв, "Залуус" цахим телевиз болгон хөгжүүлэхээр ажиллаж байна. Мөн 18001893 дуудлагын утсанд дунджаар жилд 4300, өдөрт 30-100 дуудлага хүлээн авч байна. Мөн "Цахим хууль зүйн зөвлөгөө" хуудсаар дамжуулан 38 хүнд цахимаар, 21 хүнд биечлэн иргэний болон эрүүгийн хуулийн зөвлөгөөг өгсөн. "Цахим сэтгэл зүйн үйлчилгээ" хуудсаар дамжуулан 257 хүнд цахимаар, 35 хүнд биечлэн зөвлөгөө өгсөн.

2022 оны байдлаар аймаг, нийслэл, дүүргүүдийн хэмжээнд Гэр бүлийн зөвлөгөө өгөх нийт 27 төв ажиллаж, нийт 14257 иргэнд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. Гэр бүлд чиглэсэн мэргэжлийн үйлчилгээг

									иргэдэд хүргэх зорилготой “Гэр бүлийг дэмжих жишиг төв”-ийг нийслэлд байгуулахаар ажиллаж байна.		
4	Арга хэмжээ 2.3.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.	-	-	1.Ахмад настны хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах: Үүнд: -Үзэл баримтлал 1 -Хуулийн төсөл 1 -Тандан судалгаа -Зардлын тооцоо 1 -Засгийн газрын хуралдаан	1.Ахмад настны хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр 2020-2023 онд хэрэгжинэ. 2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр 2018-2022 онд хэрэгжинэ. 3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний	1.Ахмад настны хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн 2020 оны биелэлтийн дундаж 90.2 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн гэж” үнэлэгдсэн. 2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн 2020 оны биелэлтийн дундаж 81.0 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж	2021-2025	Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангасан байна. -Хуулийн төслийг эцэслэн боловсруулсан байна. -Зардлын тооцоог боловсруулсан байна. -Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай болон 20-аас доошгүй бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулсан байна. -ХБИ болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн байна.	1. “Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр” нь Засгийн газрын 2019 оны 389 дүгээр тогтоолоор батлагдсан бөгөөд 2020-2023 онд хэрэгжинэ. Ахмад настны аж байдлыг дээшлүүлж, ядуурлаас хамгаалах, тэднийг эрүүл урт наслуулах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, амьдрах орчин нөхцлийг сайжруулахад төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг чиглүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршиж байгаа бөгөөд 4 үндсэн зорилтоос бүрдэж байна. Тэдгээр 4 зорилтын хүрээнд нийт 58 арга хэмжээг 75 шалгуур үзүүлэлтийн дагуу хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд үндэсний хөтөлбөрийн 2020 оны өөрчлөлт биелэлтийн дундаж 90.2 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн. Уг үндэсний хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтийг 2022 оны 03 дугаар сард дүгнэсэн.Үндэсний хөтөлбөрийн биелэлт 90.0 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдлээ. ХНХ-ын сайдын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/47 тоот тушаалаар “Ахмад настны хөгжил, хамгааллын	70	

			<p>ы тэмдэглэл 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулах 4. Саадгүй байдал, хүртээмжин тухай анхдагч хуулийн төслийг боловсруулан батлуулах 5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг байгуулах 6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийг байгуулах 7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрдийг батлан хэрэгжүүлэ</p>	<p>эрхийн тухай хууль 2016 онд батлагдан хэрэгжиж байна.</p>	<p>үнэлэгдсэн. 3. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль нь 12 бүлэг, 45 зүйлтэй. 4. Саадгүй байдал, хүртээмжин тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж байна. 5. Орон нутагт одоогоор хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв байхгүй. 6. Одоогоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төв байхгүй. 7.</p>		<p>үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г баталсан бөгөөд он тус бүрээр шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхойлсон. Хамтран ажиллах байгууллагууд 2022 оны төлөвлөгөөний дагуу арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Монголын Ахмадын Холбоотой 2022 онд хамтран ажиллах гэрээнд Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг төлөвлөн улсын төсвөөс 124,9 сая төгрөгийг төсөвлөн хэрэгжүүлж байна. 2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, тэднийг нийгмийн бүхий л харилцаанд бүрэн дүүрэн оролцох, ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх ойлголт, хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх, тэдэнд ээлтэй нийгмийн орчинг бүрдүүлэх зорилготой. Уг хөтөлбөр нь Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор батлагдсан бөгөөд 2018-2022 онд хэрэгжсэн. Үндсэн 8 зорилтын хүрээнд нийт 114 үйл ажиллагааг төлөвлөсөн бөгөөд 2020 оны биелэлтийн</p>	
--	--	--	--	--	---	--	---	--

			<p>х 8. Ахмад настныг /ажилтныг/ тэтгэвэрт бэлтгэх жишиг загварыг хэрэгжүүлэх.</p>	<p>ХЭБХЗГ-аас авах. 8. 2020 онд 4000 гаруй байгууллага хэрэгжүүлсэн.</p>		<p>дундаж 81.0 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн. 3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, ХЗДХ-ийн сайдтай хамтран үзэл баримтлалыг батлуулсан. Хуулийн төслийг яамд болон холбогдох төрийн болон ТББ-дад танилцуулан саналыг тусгасан бөгөөд ойрын хугацаанд ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль нь 12 бүлэг, 45 зүйлтэй бөгөөд шинэчилсэн найруулгын төсөл нь нийт 12 бүлэг, 43 зүйлтэй болж, үндсэн асуудлаар 1 бүлэг, шинээр 6 зүйл нэмэгдэж, хуулийн 70 гаруй хувьд нь нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулга орсон байна. 4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд “Саадгүй байдал, хүртээмжийн тухай” анхдагч хуулийн төслийг боловсруулан батлуулахаар ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн дүүрэн бие даан оролцох нөхцөлийг бүрдүүлэх, аливаа саад учрахаас урьдчилан сэргийлэх, учирч буй саадыг арилгах мөн тэдэнд барилга</p>
--	--	--	--	--	--	--

						<p>байгууламж, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбоо зэрэг үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор уг хуулийн төслийг боловсруулсан. Энэ оны 12 дугаар сард хуулийн төслийг холбогдох төрийн болон ТББ-дын төлөөлөлд танилцуулж, саналыг тусгасан.</p> <p><b>5.</b>Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкттай 2018 оны 4 сарын 4-ний өдөр байгуулсан гэрээ, хэлэлцээрийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах” төслийг хэрэгжүүлж байна.Тус төслийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-ийн барилга 6 аймагт баригдахаар төлөвлөгдсөн.Энэ онд Ховд, Дорнод, Дундговь, Дархан-Уул, Хөвсгөл аймагт барилга бүрэн баригдажашиглалтад орсон байна. Архангай аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгын гүйцэтгэл 45%-тай байна. 6 аймгийн барилгын санхүүжилтэд 2022 онд 17,250,000,000.00 төгрөг санхүүжилт төсөвлөгдсөнөөс</p>
--	--	--	--	--	--	---



								15,795,439,082.70 төгрөгийн санхүүжилт хийгдээд байна. Дээрх аймгуудад “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-ийг “Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын тухайн орон нутаг дахь салбар хэлбэрээр байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлэх арга хэмжээ авахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяад даалгасан Засгийн газрын 2021 оны 164 дүгээр тогтоол батлагдсан. Төвийн бүтэц, зохион байгуулалт, ажиллах дүрмийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 8 дугаар сарын 17-ны А/159 дүгээр тушаалаар баталсан. 6.Улаанбаатар хотод барих Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн барилгын зураг, төсвийг 2021 оны 12 дугаар сард батлуулсан. Тус төвийн барилга угсралтын ажил гүйцэтгэх сонгон шалгаруулалтын дотоодын тендерийг 2022 оны 2 дугаар сард зарлаж, гүйцэтгэгч байгууллагыг шалгаруулж, гэрээ байгуулаад байна. Барилга угсралтын ажлыг 2022 оны 06 дугаар сард эхлүүлсэн. Барилга угсралтын ажил 24%-тай явагдаж байна. Тус барилгад 3,067,963,881.21 төгрөгийн санхүүжилт хийгдээд байна.
--	--	--	--	--	--	--	--	---

						<p><b>7.Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, ажлын байр бий болгохыг дэмжих, хадгалах чиглэлээр 2022-2023 онуудад хэрэгжүүлэх “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” “Ногоон ажлын байр хөтөлбөр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” нийт 7 хөтөлбөрийг боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 02 сарын 11-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлэн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2022-2023 оны хөтөлбөр” батлах тухай Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлуулсан.</b></p> <p><b>8. ХНХЯ-ны аймаг, нийслэлийн ахмадын хорооны дарга нартай байгуулсан Хамтран ажиллах гэрээнд Ахмад настныг тэтгэвэрт гарахад бэлтгэх чиглэлээр ажил олгогчийг өндөр насны тэтгэвэр тогтоолгох хугацаа дөхсөн болон тэтгэвэр тогтоолгож байгаа ахмад настан /ажилтан/-ыг нийгэм,</b></p>
--	--	--	--	--	--	--

									эдийн засаг, сэтгэл зүйн хувьд бэлтгэх жишиг загварыг хэрэгжүүлж байгаа бөгөөд 2022 оны байдлаар нийт 7228 аж ахуйн нэгж байгууллага хэрэгжүүлж байна.	
5	2.3.5. хүүхдийн эрхийг дээдлэн, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, хөдөлмөрийн мөлжлөгөөс ангид байлгах чиглэлээр эрх зүйн орчныг чангатгаж, хэрэгжилтэд хатуу хяналт тавих тогтолцоог бий болгоно.	36.36 0.000	26.360.00 0	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл боловсруулах	2020	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийгдсэн.	2022	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулж, холбогдох талуудаар хэлэлцүүлсэн байна.	-Хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг салбар бүрт танилцуулж, зөвлөмж хүргүүлэх, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, дагалдах Хүүхдийн эрхийн тухай хуулийн төсөлд санал авах хэлэлцүүлгийг 2021 оны 10-12 дугаар саруудад үе шаттайгаар зохион байгуулсан. -2022 оны Төсвийн тухай хуулийг дагалдан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10.5-д Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх аргачлалыг хүүхэд хамгааллын болон төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтарч батална" гэсэн нэмэлт орж батлагдсанаар хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг тооцох, санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалттай болсон. 3/ Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталсан үзэл баримтлалын	90

									дагуу боловсруулж, 2022 оны 2-6 дугаар сард Засгийн газрын гишүүд болон олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулсан. 2022 оны 09 дүгээр сард Засгийн газрын бүрэлдэхүүн шинэчлэгдсэн тул Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авч байна.	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

**Зорилт 2.6.Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлнэ:**

6	2.6.1. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг шинэчилж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн, цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгоно.	-	-	1.хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийг шинэчлэх 2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг шинэчлэх	2020	1.ХТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн	2022	1.Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж шинэчлэгдсэн байна. 2. ХАБЭАТХ-д нэмэлт өөрчлөлт оруулсан байна.	1. Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг УИХ-ын 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа баталсан. Хуулийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж байна. 2. Нийгмийн даатгалын багц хуулинд өөрчлөлт орж байж ХАБЭАТХ-д нэмэлт өөрчлөлт орох тул хугацаа болоогүй болно.	90
7	2.6.2. ажилгүйдлийн даатгалын тогтолцоо боловсронгуй болж, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг	59.7 тэрбум төгрөг ХЭДС	11 сарын байдлаар 39.3 тэрбум төгрөг	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр – 5; Тушаал; удирдамж.	2021	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2020 оны 01 дүгээр тогтоолоор үндсэн 5 хөтөлбөрийг баталсан. ХЭҮЗ-ийн 2022 оны 01 дугаар тогтоолоо	2022	Хөтөлбөрдийн төслийг хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр оруулан батлуулсан байна. Холбогдоох удирдамж, бичиг баримтыг сайдын	Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, ажлын байр бий болгохыг дэмжих, хадгалах чиглэлээр 2022-2023 онуудад хэрэгжүүлэх “Хөдөлмөрт хөтөлбөр”, “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмадын	100

	нэвтрүүлэн ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.					р нэмэлт өөрчлөлт оруулан үндсэн 7 хөтөлбөр болгон баталсан.	тушаалаар батлуулсан байна.	хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” “Ногоон ажлын байр хөтөлбөр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” нийт 7 хөтөлбөрийг боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 02 сарын 11-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлэн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2022-2023 оны хөтөлбөр” батлах тухай, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх удирдамжийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/54 дүгээр тушаалаар батлуулав.		
8	2.6.3. оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг нэмэгдүүлнэ.	-	-	Цахим, зайн ажлын байр	-	шинээр	2022	“Хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих төсөл”-ийн дэмжлэгтэйгээр цахим бизнес эрхлэлт, ур чадварын сургалт, зөвлөгөө мэдээлэл олгох цахим платформ бий болгох, тэдгээрийг цахимаар сургалтад хамруулах нөхцөлийг бүрдүүлэх	Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг 2021 оны 7 дугаар сард УИХ-аас баталж, хууль 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн. Хөдөлмөрийн гэрээний төрлүүдийг өргөжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн гурвалсан харилцаа, ажлын бүтэн бус цагаар ажиллах, зайнаас ажиллах зэрэг хөдөлмөрийн гэрээний төрлөөс ажил үүргийн онцлогтой холбогдуулан сонгож байгуулахаар тусгасан. 2022 онд ХЭҮЗ-өөр “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг шинээр батлуулж, Эмэгтэйчүүдийн	100

							<p>арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.</p> <p>хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлд эргэн нэвтрэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ажиллах хүчнээс гадуур байгаа эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж, тэдэнд болон гэртээ удаан хугацаагаар хүүхдээ харж буй бага насны хүүхэдтэй ээжүүдэд хөдөлмөрлөх боломж олгох хүрээнд богино хугацааны ур чадвар олгох, гэрээс болон зайнаас ажиллахыг дэмжих сургалтуудыг 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн хэрэгжилтийг 2022 оны 11 сарын байдлаар өссөн дүнгээр харуулвал 2,627 иргэн хамрагдаж 355,476,925 төгрөгийг зарцуулж 268 ажлын байр бий болсон байна.</p>			
9	2.6.4. албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулна.	-	-	Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн мэдээллийн сан-1	-	-	2022	<p>Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаарх сүүлийн 10 жилийн тоо, мэдээллийг үүсгэсэн байна.</p> <p>Албан бус сектороос албан хөдөлмөрт шилжснээр нь иргэдийн хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгаалал нь баталгаатай болж, цаашлаад улсын дотоодын нийт бүтээгдэхүүн болон нийгмийн даатгалын сан, татварын орлого зэрэгт эерэг нөлөөллийг үзүүлэх үр дүнтэй. Албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан хэлбэрт шилжүүлэх ажилд нөлөөлөл үзүүлэх зорилгоор албан бус хөдөлмөр эрхэлж буй ахуйн нэгж, иргэдийн мэдээллийг төрийн цахим мэдээлэл солилцох системтэй уялдуулан цахимжуулах,</p>	50	

--	--	--	--

--	--

нэгдсэн мэдээллийн санг бий болгох, системийг хөгжүүлэх ажлын талаар Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагатай хамтран ажиллаж байна. Албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан салбарт шилжүүлэх бодлогын хүрээнд албан бус салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ахуйн нэгж, иргэдийн мэдээллийг цахимжуулах ажилд Үндэсний зөвлөх сонгон шалгаруулан ажиллуулж, одоогоор өнөөгийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулах судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тодорхой хүрээг хамарч буй одоо ашиглагдаж буй системүүд болон тэдгээрийн зарим модулуудыг албан бус хөдөлмөрийг албажуулахад ашиглах боломжтой байна. Одоогийн байдлаар албан бус хөдөлмөрийг албажуулах асуудал нь аль ч системийн хувьд үндсэн зорилгод хамаарахгүй байгаа бөгөөд тухайн системүүдээс албан бус хөдөлмөр эрхлэлтийн зохистой мэдээллийн сан үүсгэхэд хүндрэлтэй байна. Иймд албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэлийг нэг дор цуглуулах, боловсруулах боломжийг бий болгосон шийдэл боловсруулах, оролцогч талуудын үр дүнтэй хамтын ажиллагаа, манлайлалыг





--	--	--	--

--	--

<p>газрын тогтоолын төслүүдийг боловсруулаад байна.</p> <p>1.Төрийн албаны цалингийн олон шатлал, зэрэглэлийг төрийн захиргааны 15 зэрэглэлийг 10, төрийн тусгай албаны 18 зэрэглэлийг 10 болгон цэгцэлж, албан хаагчдын үндсэн цалинг нь одоо мөрдөгдөж байгаа цалингийн шатлалын хамгийн өндрөөр нь тогтоож, цалингийн нэг шатлалтай болгоно. Энэ арга хэмжээний хүрээнд төрийн захиргааны 20 мянга, төрийн тусгай албаны 40.7 мянга албан хаагчдын цалин 12-15 хувь нэмэгдэх бөгөөд нийт 141.3 тэрбум төгрөг зарцуулах юм.</p> <p>2.Төрийн нийтлэг үйлчилгээний 22.0 мянган албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээг 8 хувиар нэмэгдүүлэх ба нийт 54.5 тэрбум төгрөг зарцуулна.</p> <p>3.Орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид 20 хувийн орон нутгийн нэмэгдлийг улсын төсвөөс олгодог болно. Орон нутагт ажиллаж байгаа 12.0 мянган албан хаагчид 33.9 тэрбум төгрөг зарцуулна.</p> <p>4.Төрийн албан хаагчийн ажилласан жил бүрийг үнэлж нэмэгдэл олгодог болно. Энэ арга хэмжээний хүрээнд 160.0 мянган албан хаагчдын цалин 2-5 хувиар нэмэгдэх ба нийт 50.1 тэрбум төгрөг зарцуулах юм.</p>
---

ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

Зорилго 3.Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.

Зорилт 3.1.Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчилнэ:

11	3.1.1. нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчилж даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдэн, хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийгдэнэ.	223.6 мян.\$	107.8 мян.\$	Хуулийн төсөл	2020	Нийгмийн даатгалын эрх зүйн шинэчлэл хийгдээгүй, олон давхаргат тэтгэврийн тогтолцоо бүрдээгүй байна.	2022	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.	70	Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлэв. УИХ дахь олонхын бүлгээс “Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттай шилжүүлнэ” гэсэн бодлоготой уялдуулан нийгмийн даатгалын багц хуулийг дахин боловсруулж өргөн мэдүүлэх чиглэлийг 2022 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Засгийн газарт өгсөн. Энэхүү чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслүүдийг буцаан татаж, дахин боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 1/1385 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсантай
----	---	-----------------	-----------------	---------------	------	---	------	--	----	--

							<p>холбогдуулан хуулийн төслүүдийг дахин буцаан авч, үзэл баримтлал, тандан судалгааг боловсруулан батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/3041 тоот албан бичгээр хүргүүлсэн. Түүнчлэн хуулийн төслийг шинэчлэн боловсруулсан үзэл баримтлалд нийцүүлэн дахин боловсруулж, Засгийн газрын гишүүд болон холбогдох байгууллагуудаас санал авахаар хүргүүлээд байна.</p> <p>Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл нь одоо мөрдөгдөж буй эв санааны нэгдлээс хуримтлалын тогтолцоонд шилжих, нийгмийн даатгалаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр нь даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаа, төлсөн шимтгэлийн хэмжээтэй уялдаатай байх, мөн санхүүгийн тогтвортой, бие даасан, найдвартай байдлыг хангасан байх зэрэг зарчимд үндэслэн боловсруулж, шинэчлэлийн асуудлыг тусгав.</p>	
		Хуулийн төсөл боловсруулсан эсэх	2020	Шинээр боловсруулах	2022	Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулсан байна.	<p>Монгол Улсын Их Хурлаас 2020 онд баталсан “Алсын хараа-2050”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүд батлагдсантай холбогдуулан Нийгмийн</p>	

								<p>даатгалын багц хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/197 дугаар тушаалаар байгуулсан. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдөр хамтран батлуулав.</p> <p>Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг шинэчлэх ажлын хүрээнд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулав. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл нь 11 бүлэг, 60 зүйлтэй. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үнэлгээ, эдгээр хуулиудын төсөлтэй хамт өргөн мэдүүлэх хуулиудын төсөл болон хуулийн төслийг хэрэгжүүлэхэд нэмэгдэж гарах зардлын тооцоог тус тус хийж гүйцэтгэсэн. Энэхүү хуулийн төслийг дагалдуулан 13 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.</p> <p>“Хувийн нэмэлт тэтгэврийн тухай” хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ хийж, тайлан боловсруулав.</p>	
--	--	--	--	--	--	--	--	--	--

								<p>Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд санал авах зорилгоор хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, холбогдох судалгааны хамт бүх яамдад 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 1/1745 тоот албан бичгээр, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо болон холбогдох төрийн бус байгууллагуудад 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 1/1755 тоот албан бичгээр, Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банкинд 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 1/1755 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.</p> <p>Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн ээлжит уулзалт, хэлэлцүүлгийг 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулав. Уг ажлын хэсэгт Монголын хөрөнгийн бирж, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Ард лайф ХХК, Тэтгэврийн ууган сан, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөлөл, мөн актуарч, холбогдох судлаач нарын төлөөлөл оролцсон.</p> <p>Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн Газрын хуралдаанаар хэлэлцэн</p>	
--	--	--	--	--	--	--	--	---	--

								<p>дэмжиж, 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэв. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн хүрээнд “Хувийн нэмэлт тэтгэврийн үүсэл, Монгол Улсад нэвтрүүлэхэд анхаарах асуудлууд” сэдэвт өгүүллийг Монголбанкнаас эрхлэн гаргадаг Мөнгө, санхүү баялаг сэтгүүлд хэвлүүлэв.</p> <p>23 гадаад улсын хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцооны тухай судалгаа хийв.</p>		
			Хуримтлалын нэгдсэн сан байгуулагд аагүй байна.	2020	Шинээр боловсруулах	2022	Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийг боловсруулсан байна.	<p>Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьчилан тандсан судалсан тухай тайланг боловсруулж дуусав.</p> <p>Голланд, Сингапур, Казахстан, Норвеги, Чили зэрэг тэтгэврийн хуримтлалын тогтолцоотой орнуудыг сонгон авч судлав. Сингапур улсын Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийг орчуулж судалгаанд ашиглаж эхлэв.</p> <p>Бүгд Найрамдах Сингапур Улсын Сингапурын хамтын ажиллагааны байгууллага (SCE)-тай 2021 оноос хойш удаа дараа харилцан санал солилцож, хамтран ажилласны үр дүнд Монгол Улсын Ерөнхий сайдын Бүгд Найрамдах Сингапур Улсад хийсэн айлчлалын хүрээнд 2022 оны 07 дугаар сарын</p>		

--	--	--	--	--	--	--	--	--	--

07-ны өдөр Сингапурын хамтын ажиллагааны байгууллага (SCE)-тай хамтран ажиллах санамж бичгийг гурван жилийн хугацаатай байгуулав. Монгол Улсад Хуримтлалын нэгдсэн сан бий болгоход дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ авах ажлын даалгаврыг боловсруулж Дэлхийн банкинд хүргүүлж батлуулсан. Энэхүү техникийн нөхцөлийн дагуу Сингапураас авах зөвлөх үйлчилгээний 1 ба 2 шатны тодорхой хэсгийг Дэлхийн банкнаас Сингапурын хамтын ажиллагааны байгууллага (SCE)-тай 2022 оны 08 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан гэрээгээр санхүүжүүлэхээр болов. Хуримтлалын нэгдсэн сантай хамтран ажиллах чиг үүрэг бүхий Удирдах хороог Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн А/153, уг Удирдах хорооны ажилд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн А/144 дүгээр тушаалаар батлуулав. 2022 оны 8 дугаар сарын 10-16-ны өдрүүдэд Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын зөвлөх үйлчилгээний 5 хүний бүрэлдэхүүнтэй баг Монгол Улсад ажиллав. Зүүн өмнөд Азийн газрын захирал ноён

--	--	--	--	--	--	--	--	--	--

<p>Тан По Тек, Сингапурын Хуримтлалын нэгдсэн сангийн ТУЗ-ийн гишүүн Юэ Ёон Кан Дон, Со Чен Хэн, менежер Чиа Зао Рү, зөвлөх Лим Чи Киа нарын төлөөлөгчид Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Эрүүл мэндийн яамны удирдлагуудтай албаны уулзалт хийж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, түүний харьяа агентлаг Нийгмийн даатгалын ерөнхий газар, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс зэрэг байгууллагуудад ажиллаж, үйл ажиллагаатай танилцав. Сингапур Улсад Хуримтлалын нэгдсэн сангийн тогтолцоог бий болгож, хөгжүүлсэн туршлагаас хуваалцах сургалтыг 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдөр Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын зөвлөх үйлчилгээний баг зохион байгуулав. Уг сургалтад холбогдох яамд, агентлаг, төрийн бус байгууллага, судлаачдын 100 гаруй төлөөлөл оролцов. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын зөвлөх үйлчилгээний багаас эхний шатны ажлын тайланг хүлээн авав.</p>		
---	--	--



									2022 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга тэргүүтэй ажлын хэсэг тайланг хэлэлцэх цахим хурлыг Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын зөвлөх үйлчилгээний багтай зохион байгуулж санал солилцов. Тус хуралд Сингапурын зөвлөх үйлчилгээний багийн Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын Ойрхи дорнод, хойд азийг хариуцсан захирал Тан По Тек, ахлах зөвлөх Сох Чин Хэнг, зөвлөх Каролин Чиа нар оролцож улмаар тайланг нэмж сайжруулан 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр ирүүлсэн.		
12	3.1.2. Иргэн бүр нэрийн дансандаа бодит хуримтлалтай болж, дансны үлдэгдлийн тодорхой хувийг гэр бүлдээ өвлүүлэх нийгмийн даатгалын шинэчлэл хийгдэнэ	-	-	Хуулийн төсөл	2020	Хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байна.	2022	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байна.	Шинэчлэн боловсруулсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.5-д “30.5.Даатгуулагч нас барвал түүний мөнгөжүүлсэн орлогыг хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлнэ.” гэж тусгасан бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогын тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх эрх зүйн орчин бүрдэх юм.	100	

13	3.1.3.нийгмийн халамж зорилтод бүлэгт хүрч, халамжийн үйлчилгээ ил, тод нээлттэй, чирэгдэлгүй болно.	33.6 тэрбум төгрөг	30.7 тэрбум	Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний хэрэгжилтийн байдалд судалгаа хийж, Хүнсний эрхийн бичиг олгох журамд өөрчлөлт оруулах шийдвэрийн төслийг боловсруулах	2020	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/13 дугаар тушаал 2020 онд 242988 иргэнд нийт 52.2 тэрбум төгрөг зарцуулсан.	2022	Холбогдох журмыг шинэчилсэн байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн А/103 дугаар тоот тушаалаар “Хүнсний эрхийн бичиг олгох журмыг” шинэчлэн баталсан. Уг журамд зөвхөн гэрээт дэлгүүрүүдээр үйлчлүүлдэг байсныг болиулж, НӨАТ-ын баримт буюу и-баримт хэвлэдэг 235.0 мянга орчим хүнсний дэлгүүр, зах, бөөний төвөөр үйлчлүүлэх боломжийг бүрдүүлж цахимжууллаа. Тус ажлын хүрээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг иргэдийг картжуулах, пин коджуулах, пос машины хөгжүүлэлт, хүнсний бүтээгдэхүүнийг бар коджуулах, сервисийн хөгжүүлэлт зэрэг олон ажлыг шат дараатайгаар төр, хувийн байгууллага хамтран зохион байгуулсан. Ингэснээр сард 405.0 сая төгрөг, жилд 4.8 тэрбум төгрөг хэмнэх боломж бүрдсэн. Нээлттэй, ил тод, тэгш хүртээмжтэй, сонголттой, хяналттай болгосон. Сонгон шалгаруулалтад шалгарсан зөвхөн гэрээ бүхий заасан дэлгүүрээр үйлчлүүлдэг байсныг болиулсан. Монгол Улсын хүнсний бүтээгдэхүүнийг бар коджуулах ажлын эхлэл болж байгаа юм. Мөн дата анализ хийх боломж бүрдсэн. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний	100
----	--	--------------------	-------------	--	------	---	------	------------------------------------	--	-----

								шинэчлэлд Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв УУГ, Монголын банкны холбоо, Төрийн банк, Хаан банк, Голомт банк, Хас банк, Худалдаа хөгжлийн банк, бусад арилжааны банк, Хэрэглэгчийн систем нийлүүлэгчдийн холбоо, Жи Эс-1 Монгол ТББ, Систем хөгжүүлэгч 22 байгууллага, Номин” тав трейд ХХК, “Оргил” худалдааны төв, “И Март” Скай хайпермаркет зэрэг байгууллагууд хамтран ажиллаж байгаа юм.	
			Нийгмийн халамжийн арга хэмжээг нээлттэй, ил тод, олон нийтийн хяналттай, үр дүнтэй, хүнд сурталгүй, албан тушаалтнуудын оролцоогүй болгох зорилгоор цахим хэлбэрт шилжүүлэх	2020	Нийгмийн халамжийн үйлчилгээн ий тоо 14 болж нэмэгдэн, иргэд үйлчилгээг чирэгдэлгүй хялбар авах боломжтой болсон байна.	2022	Нийгмийн халамжийн нэгдсэн систем”-ийг 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс улсын хэмжээнд нэвтрүүлж эхэлсэн. Нийгмийн халамжийн цахимжуулсан үйлчилгээний тоо 14 байсан бол 2021 оны байдлаар нийт 26 төрлийн халамжийн үйлчилгээг цахим системээр дамжуулан олгож эхэлсэн. Үүнд: 1. Ахмад настны тэтгэвэр 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр 3. 16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр 4. Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд 5. Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэвэр 6. Бүтэн өнчин хүүхдийг үрчилж авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан		



								<p>зайлшгүй шаардлагатай, дөрөв ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эх</p> <p>17. Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхэд</p> <p>18. Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн</p> <p>19. Алдарт эхийн одонгийн мөнгөн тусламж</p> <p>20. Хүүхдийн мөнгөн тэтгэмж</p> <p>21. Насны хишиг</p> <p>22. Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт 3</p> <p>23. 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж</p> <p>24. Жирэмсэн эхийн тэтгэмж / жирэмсний 5 сартайгаа төрөх хүртэлх хугацааны 5 сар/</p> <p>25. Ихэр хүүхдийн тэтгэмж</p> <p>26. Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжийг олгож байна.</p> <p>Иргэд e-mongolia, ehamj.mn цахим хуудас, төрийн үйлчилгээний цахим машин “ТҮЦ” машин, ebarimt аппликэйшнийг ашиглан нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ гаргах боломжтой юм.</p>			
14	3.1.4. Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ,	4500 \$	4500\$	Аргачлал батлуулах	2020	Аргачлал шинэчлэгд ээгүй.	2022	Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлсэн аргачлал батлагдсан байна.	Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 05 дугаар	70	Ковидын нөхцөл байдлын улмаас аргачлал шинэчлэх ажлын үйл явц

	<p>шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.</p>					<p>сарын 11-ний өдрийн А/84, А/89 дугаар тушаалаар хамтран шинэчлэн баталсан. Энэхүү аргачлалын өрхийн амьжиргааг тодорхойлох боломжтой холбогдох төрийн мэдээлэл болон судалгаа зохион байгуулж өрхийн амьжиргааг үнэлэх хосолмол байдлаар үнэлж хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд өрх-иргэнийг хамруулах юм. Мөн Монгол Улсын төсвийн 2023 оны төсөвт Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг амьжиргааны түвшинтэй уялдуулж нийт хүүхдийн 91 хувьд олгохоор болсон. Үүний дагуу өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгох буюу зөвхөн төрийн мэдээлэлд үндэслэн амьжиргааг нь тодорхойлох ажлыг зохион байгуулахаар Ерөнхий сайдын 163 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. Энэхүү ажлын хэсэг нь ХНХ-ын сайдын А/189 дугаар тушаалаар “Төрийн байгууллагууд хооронд мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохион байгуулах, програм хангамж хөгжүүлэх” Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан дэд ажлын хэсэг, “Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал, хэрэгжүүлэх журмын төсөл боловсруулах” Үндэсний</p>	<p>удааширсан. Шинэ аргачлалаар төрийн байгууллагуу дын захиргааны мэдээллийг ашиглаж эхэлж байгаа тул эдгээр мэдээллийг тулгах ажил ковидын нөхцөлд хүндрэлтэй тулгарсан. Мөн гадаад зөвлөх олдохгүй байсан. Цаашид туршилтын судалгааг зохион байгуулж, ҮСХ-той хамтран 2023 оны 1 дүгээр улиралд багтаан батлуулахаар төлөвлөөд байна.</p>
--	---	--	--	--	--	---	---

							<p>статистикийн хорооны даргаар ахлуулсан дэд ажлын хэсэг тус тус байгуулсан. Дэд ажлын хэсгүүдийн хүрээнд Дэлхийн банкнаас богино хугацаанд ажиллах гадаадын 3 зөвлөхийн хамт чинээлэг байдлын тест, орлогыг орлуулан тооцох арга, чинээлэг байдлын тест болон орлогыг орлуулан тооцох аргыг хослуулан тооцох гэсэн 3 аргачлалыг боловсруулсан. Мөн шинээр 6 загварыг нэмэлтээр боловсруулсан. Боловсруулсан загварыг Монгол Улсын нийт хүн амын мэдээлэл дээр ажиллуулж, загварыг баталгаажуулахаар бэлтгэл ажлыг хийж байна. Баталгаажсан загварыг өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох аргачлалд нэмэлт өөрчлөлтөөр оруулж ҮСХ-той хамтран батлуулахаар бэлтгэж байна. Цаашид батлагдсан аргачлалын дагуу төрийн байгууллагуудын мэдээллийн сангуудаас шаардлагатай мэдээллээс бүрдсэн өрхийн нэгдсэн мэдээллийн сан үүсэх бөгөөд энэхүү мэдээллийн санг нийгмийн халамжийн бодлого, шийдвэр болон зорилтот бүлэгт нийгмийн халамжийн үйлчилгээг ашиглах боломж бүрдүүлэхээр ажиллаж байна.</p>		
--	--	--	--	--	--	--	--	--	--

				<p>Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, халамжийн сангаас дэмжлэг хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх журмын төслийг боловсруулах</p>	2020	<p>ЗГ-ын 2017 оны 197 дугаар тогтоол</p>	2022	<p>Журмын төслийг боловсруулж, ЗГ-ын хуралдаан хэлэлцүүлэх эер хүргүүлсэн байна.</p> <p>Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн халамжийн сангаас үзүүлж байгаа тусламж дэмжлэг олгох процессын журмыг халамжийн үйлчилгээг үе шаттай цахимжуулахтай холбоотойгоор орох зарим зохицуулалтыг тусган өөрчлөн найруулж “Ахмад настанд дэмжлэг үзүүлэх, хөнгөлөлт, тусламж олгох журам”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөнгөлөлт тусламж олгох журам”, “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам”-ын төслүүдийг боловсруулан ХНХ-ын сайдын 2020 оны 2 сарын 16- ны өдрийн 1/342 тоот албан бичгээр яамдын саналыг авч нэгтгэсэн. “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын тогтоолд яамдаас ирүүлсэн саналыг тусган 2021 оны 5 сарын 3-ны өдрийн 1/1142 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>Нийгмийн халамжийн үйлчилгээний цахимжуулалт, Нийгмийн халамжийн тухай багц хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалд нийцүүлэн Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд дэмжлэг хөнгөлөлт олгох журмуудыг өөрчлөх, шинэчлэн боловсруулах зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын</p>
--	--	--	--	--	------	--	------	--



									сайдын 2022 оны 11 дүгээр сарын 06-ны А/201 дүгээр тушаалаар журмын төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий салбар дундын ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний халамжийн үйлчилгээнүүд 2022 оны 5 дугаар сараас эхлэн ehalamj.mn системд шилжиж цахимжсанд нийцүүлэн журмын төслийг боловсруулж аймаг, дүүргийн халамжийн байгууллагын саналыг авч байна.		
15	3.1.5.нийгмийн даатгалын сангийн болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг инфляцийн түвшин болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.	НД 2.383 ,1 тэрбу м.төг НХ 129.4 тэрбу м.төг			2020	350,0	2022	500,0	Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа бүх тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500.0 мянган төгрөгт, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 400.0 мянган төгрөгт тус тус хүргэхээр шийдвэрлэсэн. Ингэснээр дундаж тэтгэврийн хэмжээ 29.4 хувиар нэмэгдэж 547.2 мянган төгрөгт хүрсэн. Ийнхүү тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлснээр 197.1 мянган хүний тэтгэвэр 50.0 мянгаас дээш төгрөгөөр, 72.3 мянган хүний тэтгэвэр 100.0 мянган төгрөгөөр, 200.0 мянган хүний тэтгэвэр 150.0 мянган төгрөгөөр тус	100	

тус нэмэгдэж, дундаж тэтгэврийн хэмжээ 29.7 хувиар нэмэгдэж 548.4 мянган төгрөгт хүрээд байна.

Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх дээрх арга хэмжээнд 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 469.4 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийн нэмэгдэлд 637.3 тэрбум төгрөг нийгмийн даатгалын сангаас нэмж зарцуулахаар байна.

УИХ-аас Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл сунгасан шийдвэр гарсантай холбоотойгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн форумаас тэтгэврийн нэмэгдлийг багасгахгүй байх шаардлагыг Засгийн газарт тавьсан.

Үүнтэй холбогдуулан нийгмийн халамжийн тэтгэвэр 188 мянган төгрөгийг цар тахлын үед нэмэгдүүлсэн 288 мянган төгрөгөөр олгохоор Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 60 дугаар тогтоолоор батлуулав.

2022 оны 11 дүгээр сарын байдлаар халамжийн

									сангийн мэдээгээр 64.4 мянган иргэнд 167.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 12.1 мянган байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 14.0 тэрбум төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг тус тус олгосон байна. Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг цар тахлын үед нэмэгдүүлсэн хэмжээгээр үргэлжлүүлэн олгохоор төсвийн тооцоо, судалгааг хийсний дагуу 2023 оны Монгол Улсын Төсвийн тухай хуульд 109.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг нэмж батлуулав.	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

**Зорилт 3.3. Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ:**

16	3.3.1.залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.	11,8 тэрбум төгрөг	6.8 тэрбум төгрөг	Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл /ЗГ-ын тогтоол/	-	Шинээр хийгдэж буй ажил	-	Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төслийг боловсруулж, Засгийн газрын тогтоолоор батлуулж, хэрэгжилтийг хангасан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 58 дугаар тогтоолоор Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төслийг баталсан бөгөөд 2022 онд 4 ээлжээр 21 аймаг 9 дүүргийн нийт <b>1218</b> оролцогч тус төсөлд амжилттай хамрагдсан байна. Төслийн оролцогчдод хувь хүний суурь ур чадвар, залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, биеийн тамир сэтгэл зүйн бэлтгэл, соёл, спорт, чөлөөт цагийн үйл ажиллагаа, өнөөгийн монгол хүн, монгол ёс заншил зэрэг сэдэвчилсэн хичээлүүдийг давхардсан тоогоор 56 багш дасгалжуулагчид хамтран ажиллаж, 14 ААНБ, ажил олгогчид хөдөлмөрийн яармагт оролцсон байна.	100
----	--	--------------------	-------------------	---	---	-------------------------	---	---	--	-----

						<p>Мөн Оролцогчдын сэтгэл ханамж болон төсөлд хамрагдсанаар хүлээсэн үр дүндээ хүрч чадсан эсэхийг тодруулахад багц сургалтыг үр дүнтэй байсан гэж үзсэн залуучуудын ойролцоогоор гурван хүн тутмын нэг нь (31.6 хувь) сургалтад хамрагдсанаар өөртөө итгэлтэй, нээлтэй болж хувь хүний хөгжил сайжирсан, 22.0 хувь нь харилцаа, хандлага сайжирсан, 18.3 хувь нь ажлын байртай болсон, 6.3 хувь нь хамт олон, найз нөхөдтэй болсон, 4.8 хувь нь мэдлэгээ дээшлүүлсэн, 3.2 хувь нь ажлын чиг баримжаатай болсон нь давуу талтай байсныг илэрхийлжээ. Үүнээс үзэхэд вакумжуулсан багц сургалт нь оролцогчдын харилцааны ур чадвар, багаар ажиллах чадвар, дасан зохицох чадвар, хариуцлагатай байдал, эерэг хандлага зэрэг зөөлөн ур чадваруудыг түлхүү хөгжүүлсэн нь сайшаалтай. Мөн оролцогчдын 53.8 хувь нь сургалтад хамрагдсанаар өөрт ямар мэдлэг, чадвар дутагдаж буйг ойлгосон, 52.8 хувь нь дутагдаж буй мэдлэг, чадвараа ахиулахын тулд хийх зүйлсээ ухамсарласан, 47.4 хувь нь сурсан зүйлсээ турших, хэрэгжүүлэх боломж бүрдсэн гэж хариулсан байна. Сургалтын явцад оролцогчдод хамгийн их таалагдсан, ач холбогдол бүхий хичээл нь сэтгэл зүй, харилцаа, хувь хүний</p>	
--	--	--	--	--	--	--	--

									<p>хөгжлийн талаарх хичээлүүд, мөн бизнес санаагаа хөгжүүлэх, төсөл бичих хичээлүүд илүү сонирхолтой байсан бөгөөд, сургалтын бусад үйл ажиллагаанууд буюу бизнес аялал 33.1%, хөдөлмөрийн яармаг ажилд зуучлал 31.5%, байгууллага дээрх дадлага 26.6%, менторшип арга хэмжээ 11.1 % нь сэтгэл ханамжтай үр өгөөжтэй байсан гэдгийг онцолсон байна.</p> <p>2022 оны оролцогчдын дунд “Алсын хараа-2050” МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд миний оролцоо” сэдвээ эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулсан.</p> <p>Оролцоо төслийн 2022 оны нэгдсэн тайланг 12 дугаар сарын 25-ны дотор Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдад танилцуулахаар бэлтгэл хангаж байгаа бөгөөд, оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн мөшгих судалгааг 2023 оны II улиралд багтаан явуулж олон нийтэд танилцуулна.</p>	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

**ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ**

**Зорилго 4.Засгийн газрын хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэж, үр ашгийг дээшлүүлж, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ:**

**Зорилт 4.1.Засгийн газрын хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэж, үр ашгийг дээшлүүлж, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ:**

17	4.1.4.эдийн засаг жил бүр тогтвортой өсөж, ажил эрхлэлтийг	24.4 тэрбу м төгрөг	14.8 тэрбум төгрөг	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр – 5;	2020	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр	2022	Хөтөлбөрүүдийн төслийг хөдөлмөр эрхлэлтийн үндэсний	Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, ажлын байр бий болгохыг дэмжих, хадгалах чиглэлээр 2022-2023 онуудад хэрэгжүүлэх “Хөдөлмөрт бэлтгэх	100	
----	--	---------------------	--------------------	--	------	---	------	---	--	-----	--

	тасралтгүй нэмэгдүүлнэ.	ХЭД С		Тушаал; удирдамж.		тогтоолоор үндсэн 6 хөтөлбөрийг баталсан. ХЭҮЗ-ийн 2020 оны 02 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулан үндсэн 5 хөтөлбөр болгон баталсан.		зөвлөлөөр оруулан батлуулсан байна. Холбогдох удирдамж, бичиг баримтыг сайдын тушаалаар батлуулсан байна.	хөтөлбөр”, “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” “Ногоон ажлын байр хөтөлбөр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” нийт 7 хөтөлбөрийг боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 02 сарын 11-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлэн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2022-2023 оны хөтөлбөр” батлах тухай Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх удирдамжийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/54 дүгээр тушаалаар батлуулав.	
--	-------------------------	-------	--	-------------------	--	---	--	---	---	--

**Зорилт 4.3.Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ:**

18	4.3.2.даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах хууль, эрх зүйн орчин бүрдэж, салбарын хамрах хүрээг нэмэгдүүлнэ.			Хуулийн төсөл боловсруулсан эсэх	2020	Шинээр боловсруулах	2022	Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулсан байна.	Монгол Улсын Их Хурлаас 2020 онд баталсан “Алсын хараа-2050”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүд батлагдсантай холбогдуулан Нийгмийн	100	
----	--	--	--	----------------------------------	------	---------------------	------	---	---	-----	--

						<p>даатгалын багц хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/197 дугаар тушаалаар байгуулсан. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдөр хамтран батлуулав.</p> <p>Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг шинэчлэх ажлын хүрээнд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулав. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл нь 11 бүлэг, 60 зүйлтэй. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үнэлгээ, эдгээр хуулиудын төсөлтэй хамт өргөн мэдүүлэх хуулиудын төсөл болон хуулийн төслийг хэрэгжүүлэхэд нэмэгдэж гарах зардлын тооцоог тус тус хийж гүйцэтгэсэн. Энэхүү хуулийн төслийг дагалдуулан 13 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.</p> <p>“Хувийн нэмэлт тэтгэврийн тухай” хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ хийж, тайлан боловсруулав.</p>	
--	--	--	--	--	--	--	--

								<p>Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд санал авах зорилгоор хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, холбогдох судалгааны хамт бүх яамдад 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 1/1745 тоот албан бичгээр, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо болон холбогдох төрийн бус байгууллагуудад 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 1/1755 тоот албан бичгээр, Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банкинд 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 1/1755 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.</p> <p>Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн ээлжит уулзалт, хэлэлцүүлгийг 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулав. Уг ажлын хэсэгт Монголын хөрөнгийн бирж, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Ард лайф ХХК, Тэтгэврийн ууган сан, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөлөл, мөн актуарч, холбогдох судлаач нарын төлөөлөл оролцсон.</p> <p>Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн Газрын хуралдаанаар хэлэлцэн</p>	
--	--	--	--	--	--	--	--	---	--



									дэмжиж, 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэв. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн хүрээнд “Хувийн нэмэлт тэтгэврийн үүсэл, Монгол Улсад нэвтрүүлэхэд анхаарах асуудлууд” сэдэвт өгүүллийг Монголбанкнаас эрхлэн гаргадаг Мөнгө, санхүү баялаг сэтгүүлд хэвлүүлэв. 23 гадаад улсын хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцооны тухай судалгаа хийв.		
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

**Зорилго 7.ДОЛОО.АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ**

**Зорилт 7.3. Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ:**

19	7.3.6.Иргэд гэр бүлдээ амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг олгох, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүүхдийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ.	270.000.000	270.000.000	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээн ий чанар, хүртээмж дээшилж, үйлчилгээн ий бүртгэлийг цахимжуулсан байна.	2020	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх мэдээллийн систем бий болсон.	2022	Хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд мэдээллийн сангийн хөгжүүлэлтийг сайжруулна.	Тус мэдээллийн сан нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 2017 онд батлагдсан холбогдох журмын хүрээнд боловсруулагдсан. Сангийн яамнаас гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг хамтарсан багийн механизмаар дамжуулан хүргэх асуудлыг хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн тогтолцоотой хамтад нь авч үзэж, дээр дурдсан зарчмын хүрээнд цогцоор шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэний дагуу ХНХС, Сангийн сайдын хамтарсан 2022 оны А/23, А/27 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын	90	
----	---	-------------	-------------	---	------	---	------	---	--	----	--

								<p>үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-тай уялдуулан "Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам"-ыг шинэчлэн боловсруулаад байна. Мөн ХНХС, ХЗДХС-ын 2017 оны А/173, А/120 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Нхөцөл байдлын үнэлгээ хийх" журмыг дээрх аргачлалын дагуу өөрчлөлт хийх шаардлагатай болсон. 2023 онд эдгээр журмууд батлагдсанаар тус мэдээллийн сангийн бүртгэлийн цэсийг нэмэлтээр хөгжүүлэх шаардлагатай.</p> <p>Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 33 Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрыг тус санд холбосон бөгөөд шинээр ашиглалтад орсон Налайх дүүргийн Түр хамгаалах байрыг холбож байна.</p>	
--	--	--	--	--	--	--	--	---	--

**ЕС.УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ**

**Зорилго 9.1.Зорилго 9.1. Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.**

20	9.1.1.нийгмийн үйлчилгээний байгууллагуудын (сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага, залуучууд	635.6 сая	635.6 сая	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамрагдсан хүний тоо	2018	19 Нэг цэгийн үйлчилгээний төв 20 Түр хамгаалах байр	2022	Түр хамгаалах байрны чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хамгаалах байрны үйл ажиллагаа тогтворжсон байна.	-Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 35 Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байраар 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 4392 хүнд аюулгүй байдлын хамгааллын үйлчилгээ үзүүлсэн. Үүний 2952 нь хүүхэд байна. НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран хэрэгжүүлж буй "Жендэрт	100
----	---	-----------	-----------	---	------	--	------	---	--	-----

	<p>хөгжлийн төв, хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.</p>																	
																		<b>91.5</b>

суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн хүрээнд тус яамнаас Архангай, Дархан-Уул, Ховд аймгуудын Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2022 онд Архангай, Дархан-уул, Ховд аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх Түр хамгаалах байранд 138,7 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлээд байна.

- Улсын хэмжээнд 21 байгууллагын 30 халамж, асрамжийн төвд 0-18 насны нийт 974 хүүхэд, залуус өсч хүмүүжиж байна.

2022 онд асрамж халамжийн төвөөс 59 хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэж, эргэн нэгтгэх боломжтой 42 хүүхдийн гэр бүлийн нөхцөл байдалд үнэлгээ хийж хамтарсан баг, гэр бүл асрамжийн төв хамтран хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний журмын дагуу ажиллаж байна.